

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн Захирлын
2022 оны 04. сарын 29. нийний өдрийн
А.../5 тоот тушаалын 1.р. хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ИНКУБАТОРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

- 1.1.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын оюуны өмчид тулгуурласан шинэ дэвшилтэт технологи, мэдлэгт сууринсан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нэвтрүүлэх, импортыг орлох, экспортын чиг баримжаатай бизнесийг хөгжүүлэх, бойжуулах гарааны компаниудыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв /цаашид “Судалгаа хөгжлийн төв” гэх/-ийн инкубаторт сонгон шалгаруулах, элсүүлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, төгсгэхтэй холбоотой харилцаанд энэхүү журмыг мөрдлөг болгоно.
- 1.1.2. Инкубаторын үйл ажиллагаа нь Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Ихиновацийн тухай хууль, Компаний тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Патентын тухай хууль, Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулагдана.

ХОЁР. ИНКУБАТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1. Судалгаа хөгжлийн төв нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын гарааны компанийг бойжуулах үйл ажиллагааны хүрээнд дараах үйлчилгээг үзүүлэх:
- 2.1.1. Инкубаторын үйлчилгээ үзүүлэх хугацааг “Инкубаторын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-нд тусгайлсан заана;
- 2.1.2. Ажлын байр, албан тасалгаа, уулзалт мэдээллийн заалны түрээсийн төлбөр, ургал зардалд зохих хөнгөлөлт үзүүлэн үйл ажиллагаа явуулах нөхцлийг буурдүүлнэ, /Цахилгаан дуулааны, интернэт, зэрэг тохиросноос дэвсэн зардлыг бойжиж хариуцах/
- 2.1.3. Хууль, эрх зүй, санхүү, маркетинг болон бусад мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалтанд хамруулах;
- 2.1.4. Туршилт, судалгааны ажилд хөндлөнгийн хяналт баталгаажуулах;
- 2.1.5. Эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- 2.1.6. Гадаад, дотоодын үзэсгэлэн яармагт зуучлах;
- 2.1.7. Судалгаа хөгжлийн төвийн мэдээллийн сувгаар үйл ажиллагааг сурталчлан таниулах;
- 2.1.8. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн чийдвэрийн яамны шийдвэрийг үндэслэн бойжигч компаний байрны түрээсийн төлбөрийг хөнгөлөх эсвэл чөлөөлөх, мөн бусад дэмжлэгийг үзүүлж болно.

Гурав. ИНКУБАТОРЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ

- 3.1 Судалгаа хөгжлийн төв нь шинээр элсэлт авах нөхцөл бурдсан тохиолдол тухай бүр сонгон шалгаруулалт зарлан журмын дагуу инкубаторт элсүүлнэ.
- 3.2 Инкубаторт элсэх зарлалыг ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд байршуулж нийтэд зарлаж мэдээлнэ.
- 3.3 Шалгаруулалтын тухай зар мэдээнд дараах зүйлийг тусгана.

Үнд:

- 3.3.1 Инкубаторын үйл ажиллагааны талаарх танилцуулга.
- 3.3.2 Инкубаторын нөхцөл, элсэгчид тавигдах шаардлага, сонгон шалгаруулалтанд ирүүлэх баримт бичиг, тесөл, хүлээн авах эцсийн хугацаа, сонгон шалгаруулалтын хугацаа.
- 3.3.3 Хаяг байршилын талаарх мэдээлэл, лавлагат, утасны дугаар, цахим хаяг.

Дөрөв. ИНКУБАТОРТ ЭЛСЭХЭЭР ХҮСЭЛТ ГАРГАСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1 Инкубаторт элсэхээр хүсэлт гаргасан хуулийн этгээд нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үнд:
 - 4.1.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг нэвтрүүлэх инноваци бүхий эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд эзлтэй, дэвшилтэг технологид сууритсан болино хугацаанд хөгжих боломжтой бизнесийг дотоод гадаадын зах зээлд эрхлэхээр төлөвлөсөн төсөлтэй байх.
 - 4.1.2 Инкубаторт байрших хугацаанд дагаж мөрдех, улирал тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавих болоплоо бүхий бизнэс төлөвлөгөөтэй байх.
 - 4.1.3 Инкубаторт байх хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах.
 - 4.1.4 Үйл ажиллагаагаа эрхлэх санхүүгийн чадвартай байх.
 - 4.1.5 Зөвхөн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулах ба үндсэн ажилтнуудыг байршиулах.
 - 4.1.6 Бойжигч компаниудад зориулсан сургалт, судалгаа болон олон нийтийг хамарсан арга хэмжээнд идэвхтэй оролцох.
 - 4.1.7 Судалгаа хөгжлийн төвийн байршиж байгаа байр болон эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах.
 - 4.1.8 Хагас жил тутам санхүүгийн тайланг үнэн бодитоор гаргаж, Судалгаа хөгжлийн төвд ирүүлэх. Бусад шаардсан бүхий л мэдээлээр хангахаа зөвшөөрсөн байх. /Энэхүү мэдээллийг инкубаторын үйл ажиллагааны/ үнэлгээний үндсэн үзүүлэлтийг гаргахад ашиглана/
 - 4.1.9 Инкубаторт элсэгч нь дээрх ерөнхий шаардлагыг хангасан байхаас гадна элсэлтэд тавигдах бусад тусгай шаардлагыг хангасан байна.
 - 4.1.10 Хүсэлт гаргагч нь сонгон шалгаруулалт явцад энэхүү журмын зүйл заалтыг зөрчсөн болох нь нотлогдвол хүсэлт гаргагчийг сонгон шалгаруулалтад оруулахаас татгалзах, элсэгч журам зөрчвэл гарзэг цүцлах үндэслэл болно.

Тав. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- 5.1 Инкубаторт элсэх хүсэлт гаргагч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтадаа шударга, ил тод, эрх тэгш өрсөлдөөний зарчмыг баримтална.

5.2 Сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт хүсэлт гаргагчаас ирүүлсэн бичиг баримт, төсөлд үнэлэлт дүгнэлт өгөх ба шалгаруулалт явуулсан өдрөөс хойш 20 хоногийн дотор ур дунг танилцуулна.

5.3 Ажлын хэсгийн гишүүд нь сонгон шалгаруулалтанд ирүүлсэн төсөл, түүнтэй холбогдох мэдээллийн нууцлалыг чандлан сахих ширэг хүлээнэ.

5.4 Инкубаторын элсүүлэх сонгон шалгаруулалтын ажлыг 2 үе шаттайгаар зохион байгуулна.

5.5 Инкубаторт элсэгчдэд тавигдах шаардлагыг хангагуй, бичиг баримтын бурдалт дутуу, үнэн бодит бус хуурамч мэдээлэл ирүүлсэн, хугацаа хоцорсон хүсэлт гаргагчийг сонгон шалгаруулалтанд оруулахгүй.

5.6 Инкубаторын элсэлтийн урьдчилсан баримт бичгүүдийг цахимаар эсхүл бииччлэн биттуумжлэн ирүүлнэ.

5.7 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь элсэлтийн урьдчилсан баримт бичгүүдийг хүлээн авч нэгтгэн ажлын хэсэгт танилцуулна.

5.8 Ажлын хэсгийн хурлаар хүсэлт гаргагчийн материалтай нэг бүрчлэн танилцаж эхний шатны шалгаруулалтыг ажлын 14 хүртэл хоногийн хугацаанд багтаан хийнэ.

5.9 Хүсэлт гаргагч наарт эхний шатны сонгон шалгаруулалтын үр дунг хоёр дахь шалгаруулалт явуулах өдрөөс өмнө ажлын 3-аас доошгүй хоногийн дотор цахимаар болон утсаар мэдэгдэнэ.

5.10 Эхний шатанд тэнцсэн хүсэлт гаргагч нь хоёр дахь шатанд сонгон шалгаруулалт ажлын хэсгийн хуралд бизнес төлөвлөгөөгөө 10-15 минутанд багтаан танилцуулна.

5.11 Ажлын хэсэг нь хүсэлт гаргагчийн хийсэн танилцуулга, ирүүлсэн материалыг үндэслэн дараах шалгуур үзүүлэлтийн дагуу тус бур 1-10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

Үүнд:

5.11.1 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарг нэвтрүүлэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацлаг байдлыг үнэлэх

5.11.2 Шинжлэх ухаан болон техник технологийн шийдэл бүхий төслийн хэрэгжих магадлалтай эсэх

5.11.3 Хүний нөөцийн чадавхтай эсэх

5.11.4 Эдийн засгийн үр ашигтай эсэх

5.11.5 Бизнес төлөвлөгөө хэрэгжих боломжтой эсэх

5.12 Ажлын хэсгийн гаргасан оног ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэж, танилцуулах ба нийт онооны дүнгээр эрэмбэлж хамгийн өндөр онoo авсан дарааллын дагуу хүсэлт гаргагчийг шалгаруулна.

5.13 Судалгаа хөгжлийн төв нь сонгон шалгаруулалтын дунг мэдэгдсэнээс хойш ажлын

15 хоногийн дотор инкубаторт элсэгчтэй “Инкубаторын Үйлчилгээ үзүүлэх гэрээ” байгуулах ба бойжигч компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд оорчлолт оруулж болно.

5.14 Элсэгчийн бизнес төлөвлөгөө нь Судалгаа хөгжлийн төв болон инкубаторт элсэгчийн хоорондын “Инкубаторын Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний салшгүй бурэлдэхүүн хэсэг байна.

5.15 Сонгон шалгаруулалтыг шаардлагад нийцсэн санал ирээгүй тохиолдолд бүх санаалаас татгалзаж, ажлын 5 хоногт багтаан дахин сонгон шалгаруулалтыг зарланна.

5.16 Инкубаторт элсэгчдийн бойжуулах хугацаа, ажлын байр, дэмжлэгийн хэлбэрийг тухайн төслийн чиглэл, үйл ажиллагаанаас нь хамааран ажлын хэсгийн саналыг үндэслэн тогтооно.

Зурага. ИНКУБАТОРТ ЭЛСЭГЧДИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

6.1 Инкубаторт элсэхээр хүсэлт гаргагч нь Инкубаторын үйл ажиллагааны журамтай танилцан зөвшөөрсөн байх ба дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ.

Үнд:

6.1.1 Инкубаторт элсэхийг хүссэн хүсэлтээ албан бичгээр ирүүлнэ.

6.1.2 Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгажуулсан хуулбар, аж ахуйн нэгжийн дүрмийн хуулбар.

6.1.3 Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн үндсэн ажилчдын анкет, иргэний үнэмлэхний хуулбар.

6.1.4 Инновацийн төсөл

6.1.5 Бусад ижил төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс ялгарах онцлог, үйл ажиллагааны танилцуулга, оюуны өмчийн гэрчилгээ /патент, ашигтай загвар, барааны тэмдэгт гэх мэт/

6.1.6 Хүсэлт гаргагч хуулийн этгээд нь нэгзэс доошгүй жил үйл ажиллагаа явуулж байгаа бол сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан.

6.1.7 Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шаардагддаг бол эрх бүхий байгууллаас олгосон патент лиценз, эрхийн гэрчилгээ.

6.1.8 Татвар, НД, Цагдааагийн байгууллага тодорхойлолт /хуулийн этгээд/

6.1.9 Банкны өр, хугацаа хэзэрсэн зээл болон найдвартай зээлдэгчээр бүртгэгдсэн эсэх лавлагaa, тодорхойлолт.

Долоо. ИНКУБАТОРЫН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

7.1 Судалгаа хөгжлийн төвийн захирлын тушаалаар дараах ажлын хэсгүүдийг байгуулах бөгөөд “Сонгон шалгаруулах ажлын хэсэг” нь бойжигч компаниудыг сонгон шалгаруулах, “Үнэлгээний ажлын хэсэг” нь үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгнө.

7.2 Ажлын хэсгээс гарсан шийдвэрийг Захиралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

7.3 Судалгаа хөгжлийн төвөөс инкубаторын компаниудын үйл ажиллагааг улирал тутамд үнэлж, дүгнэнэ.

7.4 Жилийн эцсийн үнэлгээгээр 70-аас дээш хувийн үр дун үзүүлсэн бол үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн нэг удаа гэрээг сунгаж болно.

7.5 Инкубаторт бойжигчийн гэрээний хугацаанд үнэлгээний дундаж оноо 70-80 бол 6 сараар гэрээний хугацааг сунгаж урамшуулах ба “Инкубаторын тэгсэгч” гэрчилгээ олгоно.

7.6 Инкубаторт бойжигч нь гэрээнд заасан хугацаанд үнэлгээний дундаж оноо 90-100 бол гэрээний хугацааг 1 жилээр сунгаж урамшуулах ба “Инкубаторын шилдэг тэгсэгч” гэрчилгээ олгоно.

7.7 Бойжигч нь 3 улирал дараалан хангалтгүй үнэлгэгдсэн бол гэрээг дуусгавар болгоно.

7.8 Инкубаторын үйлчилгээнд хамрагдах хугацаа нь дууссан тохиолдолд нийт үнэлгээний дундгийг төгсөлтийн үнэлгээ гэж тооцно.



Найм. ИНКУБАТОРООС ХАСАХ

- 8.1 Инкубаторын үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хугацаа дууссан, бойжигч хүсэлт гаргасан тохиолдолд гэрээний үргийг дуусгавар болгоно.
- 8.2 Дараах тохиолдолд үнэлгээний ажлын хэсгийн саналыг үндэслэн “Инкубаторын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г дуусгавар болгож бойжигчийг инкубатороос хасна.
 - 8.2.1 Энэхүү журмыг зерчсөн, гэрээгээр хүлээсэн үргээ билүүлэзгүй;
 - 8.2.2 Хууль зерчсөн үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон;
 - 8.2.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үнэлгээнд орохоос татгалзсан;
 - 8.2.4 Үйл ажиллагаагаа эрхлэхгүй 1 сар болсон;
 - 8.2.5 Инкубаторт зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулсан;
 - 8.2.6 Судалгаа хөгжлийн төвд болон үнэлгээний хороонд бодит бус хуурамч мэдээлэл бүрдүүлэн өгсөн;
 - 8.2.7 Судалгаа хөгжлийн төвд буюу ажлын байранд архи, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтэцэд нөлөөлөх бодис нэвтрүүлсэн, хэрэглэсэн;
 - 8.2.8 Байгууллагын өмчид ноцтой хохирол учруулсан;

Ес. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1 Инкубаторын төвтэй холбогдон гарсан бүх маргааныг хэлэлцэж шийдвэрлэнэ;
- 9.2 Маргааныг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ;

Арав. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 10.1. Инкубаторт элсэхээр хүсэлт гаргагчийг сонгон шалгаруулахдаа энэхүү журмыг мөрднө;
- 10.2. Хамтран ажиллах хугацаандaa ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал, талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай мэдээллийг аливаа хэлбэрээр задруулахгүй байх, бусад этгээдийн эрх ашгийн төлөө ашиглажгүй байх үүргийн хоёр тал хүлээнэ;
- 10.3. Сонгон шалгаруулалтад оролцогч нь илт худал мэдээлэл ирүүлсэн, авлигын гэмт хэрэгт холбогдоноыг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон бол сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналыг хүлээн авахаас татгалзана;